

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/41/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 124

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/69 тоот тушаалаар тус хэлтсийг Нийгмийн даатгалын газар болгон оноосон нэрийг өөрчилсөн байна. Тайлант онд 4.3 сая төгрөгийн хөрөнгийг Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газраас шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 345.9 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Нийгмийн даатгалын ерөнхий газраас 86.4 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702900376

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,363,307.5	9,751,202.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	774,473.3	732,450.5
	Нийт хөрөнгийн дүн	10,137,780.7	10,483,653.3
	Нийт өр төлбөрийн дүн	83,840.8	305,053.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,053,939.9	10,178,599.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,137,780.7	10,483,653.3
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	69,587,135.6	74,535,269.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	69,326,088.8	74,400,323.7
	Үйл ажиллагааны үр дүн	261,046.8	134,945.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	261,046.8	134,945.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,792,893.1	10,053,939.9
	НББ-ын өөрчлөлт		(10,286.4)
	Тайлант оны үр дүн	261,046.8	134,945.9
	Эцсийн үлдэгдэл	10,053,939.9	10,178,599.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	70,224,185.5	75,739,250.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	69,680,553.8	74,454,617.9
	Үйл ажиллагааны ЦМГ	543,631.7	1,284,632.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(15,200.0)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	528,431.7	1,284,632.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,215,452.8	4,743,884.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,743,884.5	6,028,517.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	69,227,901.2	66,532,293.5
	Урсгал зардал	69,227,901.2	66,532,293.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	69,227,901.2	34,109,573.4
	Улсын төсвөөс санхүүжих	9,140,360.7	9,140,360.7
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	60,087,540.5	24,942,917.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	26,295.4
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	-	4,743,884.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,028,517.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	69,227,901.2	34,109,573.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 2,300.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Хуулийн хэрэгжилттэй холбоотой:** Хувь хүний орлогын албан татварын тайланд 2,300.0 мянган төгрөгийн цалин дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 5,519.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгч, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. ***Цалингийн зардалтай холбоотой асуудал***

Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг шалгуурын дагуу дүгнээгүй, сар бүр хавтгайруулан 5,519.0 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаал "төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 1996 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаал "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 7-д "7.Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно."-тай нийцэхгүй байна. нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварыг нэмэгдлийг олгохдоо улирал бүр шалгуурын дагуу дүгнэж олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын газар	2	2,300.0	-	-	2	2,300.0	2	2,300.0	-	-	1	-
Дүн	2	2,300.0	-	-	2	2,300.0	2	2,300.0	-	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын газар	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			